

МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА БОЛ МАРГААШИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Д.Цахилгаан*

Нэгэн зүйл:

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааны тухай олон талт мэдээ, судалгаануудыг улс улсаар нь сэдэвчлэн базаж, монгол болон гадаад хэл дээр эмхэтгэн цуврал байдлаар нийтэлж, олны хүртээл болгож байгаа нь үнэнхүү чухал ач холбогдолтой, цаг үеэ олсон эрхэм үйлс мөн. Саяхан миний бие энэ цувралын Монгол-Америк, Монгол Германы харилцаанд зориулагдсан дугааруудыг олж үзээд ийм сэтгэгдэл төрсөн юм. Мэдээллийн эрин зуунд амьдарч буй улс түмний харилцан сонирхол, эрх ашиг маргаангүй нийлж буй нэн чухал хэрэгцээ бол бие биеэ зөвөөр танин мэдэх явдал юм. Үүнийг мэдээлэл, судалгаагүйгээр яаж хийх билээ. Мэдээлэл, судалгаа бол улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааны тулгуур үндэс мөн. Иймд бодит мэдээлэл, судалгаа бол маргаашийн хамтын ажиллагаа гэсэн үг.

Нэгэн зүйл:

Дээр дурдсан жишгээр Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны болон ерөнхийдээ хятад судлалын асуудлаар анхны төрөлжсөн сэтгүүл гаргах гэж байгааг дуулаад ихэд олзуурхан үзэг цаас шүүрэн авсан минь учиртай.

Олон улс судлалын хүрээлэн энэ тусгай дугаарыг Монгол Улс, БНХАУ-ын хооронд энэ онд тохиож байгаа гурван том ойд зориулан уншигчдын гар дээр тавих гэж байгааг Л.Хайсандай захирал, Д.Шүрхүү доктор нараас дуулаад үйл явдлын залгамж

холбоог тодотгон цөөн зүйлийг тэмдэглэн дурдъя гэсэн юм.

...Миний бие Монгол, Хятад хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны болон БНХАУ байгуулагдсаны 45, 50 жилийн ойг тэмдэглэхэд элчин сайдын хувиар оролцож байв. Ой болгон хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааны өрнөл хөгжлийг үнэлж дүгнэх, ирээдүйн зорилтыг тодорхойлох үе шат болж байлаа.

Хуучин ном, баримт сэлтийг шүүрдэн үзвэл, Монгол-Хятадын харилцааны түүх ховормой. Миний өмнө “Урд айл: Бидний харилцаа” хэмээх ном байна.

Бээжин дэх манай ЭСЯ 1999 онд дипломат харилцааны 50 жилийн ойд зориулан гаргажээ. Уг номонд миний бичсэн оршилд тухайн жилийн гурван том үйл явдлыг “5+50+50” гэж томъёолсон байх юм. Таван жил өнгөрсөн болохоор одоо тэр гурван ойг “10+55+55” гэж хураангуйлаад тайлбал, энэ онд “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”-ний 10 жилийн ой, Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ой, БНХАУ байгуулагдсаны 55 жилийн ой тохиож, эдгээр тэмдэглэлт үйл явдлуудын ач холбогдлыг онцлон тэмдэглэх өргөн хүрээтэй ажил хоёр оронд өрнөж байгаа нь мөнхийн их хөрш Хятад улсын эрчимтэй хөгжлийн алхааг олон түмэнд таниулж, хамтын ажиллагааны шинэ шинэ боломжийг нээж өгөх сайхан завшаан болж байна.

* Д.Цахилгаан. Монгол Улсын Онц бөгөөд бүрэн эрхт элчин, Энх тайван, аюулгүй байдал, олон улсын хамтын ажиллагааны Монголын нийгэмлэгийн тэргүүн, доктор (Ph.D).

Нэгэн зүйл:

Таван жилийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, БНХАУ - ы н дарга Зян Зэмин нар жил хүрэхгүй хугацаанд харилцан төрийн айлчлал хийж, хоёр орны харилцааны шинэ зууны эхэн үеийн зорилтуудыг тодорхойлж байсан бол одоо хоёр орны төр засгийн дээд хэмжээний удирдагчдын албан ёсны айлчлал, уулзалт, яриа, хэлэлцээрийн удаах шинэ үе эхэлчихээд, Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагаа улам өндөр дээд шатандаа гарчихаад, өдрөөс өдөрт бодит үр ашгийг дэлгэрүүлэн өрнөж байгааг өнөөдөр хэн бүхэн үзэж, харж байгаа нь юутай эрхэм билээ.

Үйл явдалд ийнхүү асар түргэн удаалж дараалж, түүхийн хүрдийн эргэлтийг хурдасган, цаг хугацааны үнэ цэнийг өсгөж байгаа болохоор Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагаанд чухам ямар шинэ боломж нөхцөл, суваг шугам гарч байгааг болон энэ бүхнийг ашиглавал ямар үр дүн гарахыг Таны гар дээр очиж байгаа шинэ сэтгүүлийн нийтлэл, мэдээ,

судалгаанууд нээж өгөх болно гэдэгт найдаж байна.

Нэгэн зүйл:

Хятад улсад Монголын судалгаа их далайцтай, нухацтай хийгдэж, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, эрдэмтдийн нийгэмлэгүүд гээд маш олон байгууллага, хүмүүс оролцож байгааг мэдэх хүний нэгийн хувьд надад байнга бодогдож байдаг нэг юм бол өөрийн оронд Хятад судлалыг мөн тийм хэмжээнд хөгжүүлж, улмаар мэдээлэл судалгааг хоёр орны хамтын ажиллагааны хурдасгуур болгон ашиглах түвшинд хүргэх шаардлагатай гэсэн санаа билээ. Энэ санааг гүйцэлдүүлэхэд Олон улс судлалын хүрээлэнгийн шинэ цуврал маш чухал ач тустай үйлсийн үрийг тарих бөгөөд, бас одоо манайд үгүйлэгдсээр байгаа Хятад судлалын нэгэн хэсгүүдийн ажлын уялдааг сайн болгох, хятадын судалгаа хийдэг, харилцааны ажлыг хариуцдаг хүмүүсийн санаа онолоо солилцох индэр үүсгэх хэрэгт түлхэц өгөх нь дамжиггүй.

2004 оны 12 дугаар сар.